



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөгөөг баталсан:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД

(албан тушаал)



Төлөвлөгөө боловсруулсан:
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ,
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА

(албан тушаал)



2021 он
Улаанбаатар хот

**Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021-2024 оны стратеги
төлөвлөгөөний бүтэц, агуулга**

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	3-4
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	4-5
Бүлэг 3. Алсын хараа	5
Бүлэг 4. Эрхэм зорилго	5
Бүлэг 5. Орчны шинжилгээ	5-12
Бүлэг 6. Стратегийн зорилго	13
Бүлэг 7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	14-20
Бүлэг 8. Стратегийн зорилго ба Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын байгууллагын бүтцийн уялдаа, зураглал.....	21-22
Бүлэг 9. Хавсралт.....	23

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хэрэгцээ, шаардлага

Монгол орны уур амьсгал, байгаль, цаг уурын тааламжтай нөхцөлийг бүрэн дүүрэн ашиглах, цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргэжилүүлж, эрсдэлийг багасгах, улмаар улс орны тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.

Засгийн газрын 2002 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт 87.5 хувь, Засгийн газрын 2007 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт 88.0 хувийн биелэлттэй байна.

Дэлхийн дулаараг, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр Монгол оронд мөстөл хайлах, мөнх цэвдэг гэсэх, гүний ус багасах, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, аадар тунадас, үер зэрэг цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал нэмэгдэж, хуурайшилт, цөлжилт зэрэг орчны доройтол эрчимжин, улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын амьжираанд үзүүлэх сөрөг нөлөөлөл жилээс жилд нэмэгдэж байна.

Монгол орны аюулгүй байдал, эдийн засгийн үндэс болсон бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, уул уурхай, аялал жуулчлал зэрэг салбарууд нь байгаль цаг агаарын эрхшээлд оршсоор байна.

Хүн амын төвлөрөл, цаг агаарын онцлогоос шалтгаалан Улаанбаатар хот, бусад томоохон хотуудын агаар, ус, хөрсний бохирдол нэмэгдэж, иргэдийн амьдрах орчин, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл улам ихэссээр байна.

Монгол орны байгаль экологид гарч буй болон цаашид гарах өөрчлөлтийг тодорхойлох, түүнд зохицон амьдрах чадавх, бололцоогоо нэмэгдүүлэх, сөрөг үр дагаврыг сааруулах арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх, холбоо мэдээлэл, техник технологийг шинэчлэх, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмжийн дагуу гишүүн орнууд 2020 оноос өмнө мөнгөн уст хэмжлийн багажийн хэрэглээг бүрэн зогсоож, ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд автомат болон зайнлас хэмжих техник, технологийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай болсон.

1.2 Бодлого, эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталж, уг баримт бичигтэй нийцүүлэн УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл, 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталж, урт, богино хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтуудыг тодорхойлсон.

Ус цаг уур орчны хяналт шинжилгээний салбарт өнөөгийн байдлаар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Агаарын тухай, Байгалийн ургамлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Усны тухай зэрэг гол хуулиудаас гадна салбарын хамаарал бүхий 12 хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор 9

Үндэсний хөтөлбөр, нийт 11 үзэл баримтлал, үндсэн чиглэл, төлөвлөгөөг баталсан байгаа бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Салбарын ирэх 4 жилийн стратеги төлөвлөгөөнд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт, богино хугацааны бодлогууд, салбарын бусад бодлогын баримт бичгүүд, Олон Улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилго, стратегийг боловсруулж тусгасан.

2017 онд УИХ-аас шинэчилсэн найруулгаар батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасныг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг удирдлага болгон Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримталсан.

Стратеги төлөвлөгөөнд Засгийн газрын өмнөх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Ус цаг орчны шинжилгээний чиглэлээр дэвшүүлсэн зорилтын биелэлтэд хийсэн дүн шинжилгээ хийж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшинг баримтлан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үндсэн чиг үүргийн хүрээнд 10 зорилт, 41 арга хэмжээг ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлнэ. Дээрх зорилт, стратеги арга хэмжээг хэрэгжүүлэхдээ салбарын байгууллагуудын боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилан зарцуулж, дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангахаар тусгаж төлөвлөсөн болно.

Хоёр. Мандатын шинжилгээ

Мандатыг тодорхойлохдоо 2019 онд хийгдсэн чиг үүргийн шинжилгээний үр дүнд тулгуурлан Монгол Улсын Үндсэн хууль болон Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын шууд хамаарах 36 хууль, Олон Улсын гэрээ конвенц, төрийн алба, яам, агентлагийн эрхлэх асуудал, төсөв санхүү зэрэг нийт 94 хуулийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон салбарын бусад байгууллагуудад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан авч үзэж, дараах дөрвөн алхмын хүрээнд шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох.
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах.
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох.
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох.

Мандатын шинжилгээний үр дүнд 1 өрөнхий чиг үүрэг, 3 үндсэн чиг үүрэг, 13 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, доорх хүснэгтээр үр дүнг нэгтгэсэн.

Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		46
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	12
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	34
Ерөнхий чиг үүрэг-1 Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах.	1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилт, тасралтгүй ажиллагааг хангах. 2. Сүлжээг өргөтгөх, техник, технологийн шинэчлэлийг төлөвлөж хэрэгжүүлэх 3. Дотоодын болон олон улсын мэдээ солилцооны хэвийн ажиллагааг хангах. 4. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах 5. Улсын агаарын чанарын мэргэжлийн албаны үүргийг гүйцэтгэх. 6. Ус, цаг уур, орчны мэдээллийн баримтын төрийн архивыг эрхлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах.	ЦУОШГ, УЦУОСМХ, НЦУТ, БОХТЛ, Аймаг, хотын УЦУОШТ-үүд
ҮЧҮ-2: Ус цаг уур, орчны мэдээ мэдээллээр хангах.	7. Ус, цаг агаарын түүхэн, бодит болон урьдчилсан мэдээ, орчны төлөв байдлын мэдээллээр үйлчлэх. 8. Ус, цаг агаар, уур амьсгалын /ган, зуд/ гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс сээрэмжлүүлэх. 9. Тусгай хэрэгцээний мэдээгээр нийгэм, эдийн засгийн салбар /Нисэх, Төмөр зам, Автозам, ХДА, Эрчим хүч гэх мэт/-уудыг хангах. 10. Цаг агаарт зориудаар нөлөөлэх 11. Байгаль орчны мэдээллийн сан үүсгэх, удирдан зохион байгуулах.	ЦУОШГ, УЦУОСМХ, НЦУТ БОХТЛ, Аймаг, хотын УЦУОШТ-үүд
ҮЧҮ-3: Ус цаг уур, орчны эрдэм шинжилгээ, судалгаа хийх.	12. Ус, цаг агаар, хөдөө аж ахуй, орчны төлөв байдал, уур амьсгалын нөөц, түүний өөрчлөлт, нөлөөллийн судалгаа хийх. 13. Тоон загварчлал, шинэ арга зүй, инноваци, технологи боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх.	ЦУОШГ, УЦУОСМХ Аймаг, хотын УЦУОШТ-үүд

Гурав. Алсын хараа

Дэлхийн жишигт хүрсэн ус цаг уурын үйлчилгээ

Дөрөв. Эрхэм зорилго

Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах

Тав. Орчны шинжилгээ

Агентлаг нь Цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээг тасралтгүй найдвартай ажиллуулж, ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдлын бодит болон урьдчилсан, урьдчилан сэргийлэх, тусгай хэрэгцээний мэдээ, мэдээллээр

нийгмийн хэрэгцээг тасралтгүй хангах ажлыг зохион байгуулж, төр, иргэд, хувийн хэвшлийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, нийгмийн хэрэгцээнд тулгуурласан ус цаг уурын орчны мэдээ мэдээллээр мэргэжлийн түвшинд чанартай, шуурхай үйлчилж байна.

Ус цаг уурын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад орчин ихээхэн нөлөөтэй тул эдгээр орчин нөхцөлийг байнга хянаж, сайжруулж ажиллана. Үүнд:

Дотоод орчин:

- Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг чанд мөрдөж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага тавьж, хууль, тогтоомжид заасны дагуу цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл ахиулах, дэвшин ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах;
- Үйл ажиллагаагаа саадгүй явуулахад нийцсэн бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- Мэргэжилтний ур чадвар, бүтээлч санаачилга, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Үйл ажиллагааг эрэмбэлэх шалгуур үзүүлэлт гаргаж мөрдөх;
- Байгууллага, хувь хүмүүс хоорондоо хамтран ажиллаж, мэдлэг, мэдээллээ харилцан солилцох, ур чадвараасаа суралцах;
- Газрын нэгж, харьяа байгууллагуудын ажлын уялдаа, холбоог сайжруулах;
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч бүрд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдүүлж, хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх;
- Байгууллагын дотоодод мэдээлэл хуваалцах, түгээх, харилцах цахим системийг боловсронгуй болгож, шуурхай, найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Онцгой нөхцөл байдлын үеийн заавар, зөвлөмжийг дагуу шуурхай ажиллагааг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

Гадаад орчин:

Хэрэгжүүлэгч агентлагийн хувьд харилцагч талуудад чанартай үйлчилгээ үзүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын өндөр хөгжилтэй улс орон болон олон улсын байгууллагын мэдээлэл, техник технологийн ололтоос суралцах, тэдгээрийг нэвтрүүлэх үүднээс гадаад орчноо тогтмол сайжруулан ажиллана.

- Үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэх.
- Төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- Засгийн газрын бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах.

- Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэх зорилтыг хангах, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх.
- Агентлагийн манлайлал, үйл ажиллагаа, үйлчилгээг харилцагч талууд, олон нийтэд ойлгуулан сурталчлах.
- Мэдээллийг нээлттэй байлгах, харилцан солилцох.

Бодлогын баримт бичигт тусгагдсан 9 зорилт болон хуулиар ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломж ямар байгааг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан тодорхойллоо.

Дотоод орчны шинжилгээг хийхдээ салбарын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, технологийн үйл явц зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойллоо.

Гадаад орчны шинжилгээг хийхдээ УИХ, Засгийн газар, яамны бодлого чиглэл Салбарын техник технологийн чадавх, гадаад хамтын ажиллагааны зүгээс зорилтыг хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсноор ямар эерөг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргалаа.

Цаг уур, орчны шинжилгээний газрын стратегийн зорилтуудад хийсэн дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт

Стратегийн зорилт-1: Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний 135 өртөө, 181 харуул, ус судлалын 155 өртөө, харуул, 22 орчны шинжилгээний лаборатори, аэрологийн 4 өртөө ажиллаж байна. - Арга зүй, технологи хангалттай бий болсон. - Цаг уурын бодит ажиглалтын улсын сүлжээний 58% нь автомат хэмжих хэрэгслээр хэмжил гүйцэтгэж байна. - Хэмжилзүйн болон орчны хяналт шинжилгээний лабораторийг ажиллуулан сорилын болон хэмжлийн нэгдмэл байдлыг ханган ажиллаж байна. - Технологийн дотоод аудитыг хийж байна. <p>Ажиглалтын сүлжээг тасралтгүй 24 цаг ажиллуулах хүний нөөц бүрдсэн</p>	<ul style="list-style-type: none"> - Улсын сүлжээний нягтрал хангалтгүй - Цаг уурын хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай. - Цаг уурын сүлжээний 42 хувь, ус судлалын харуулын 100 хувь механик хэмжих хэрэгслээр хэмжил хийж байгаа нь хэмжлийн алдаа, тасралт үүсэх нөхцөл бий болж, хэмжлийн давтамж бага байна. - Техник, технологийн шинэчлэл жигд, хүртээмжтэй хийгдэхгүй байна. <p>Орон тоо, ургсал зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай.</p>

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> - Дэлхийн цаг уурын байгууллагын гишүүн орны хувьд арга, зүй заавар зөвлөмжөөр байнга хангагдах. - Хууль эрх зүйн орчин бүрдсэн. - Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд зарим салбарт техник технологийн шинэчлэлийг хийх. - Ус цаг уур, орчны шинжилгээний салбарыг 	<ul style="list-style-type: none"> - Монгол орны нийт нутаг дэвсгэрт дэд бүтэц жигд хөгжөөгүй. - Ус, цаг уурын ажиглалт, хэмжилд механик болон мөнгөн уст хэмжих хэрэгсэл ашиглаж байна. - ДЦУБ-ын зөвлөмж болон Менематагийн конвенцын хүрээнд мөнгөн уст хэмжих хэрэгслээс дэлхий нийтээр татгалзсан хэдий

<p>хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлэн тавьсан бодлогын санал, хууль, тогтоолын төсөл, хөтөлбөрийг УИХ, Засгийн газар, яамнаас дэмжин ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Улсын сүлжээний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Олон Улсын байгууллагын төсөл хөтөлбөр харьцангуй их. 	<ul style="list-style-type: none"> - ч манай салбарт өргөнөөр ашиглагдаж байгаа. - Орчин үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын зардал дутагдалтай. - Төрийн албан хаагчийн цалин, нийгмийн хангамжаас шалтгаалан мэргэжлийн боловсон хүчний дутагдалд орох.
---	--

Стратегийн зорилт-2: Ус, цаг уур, байгаль, орчны мэдээллийн төрийн архивыг эрхлэх, цаасан болон цахим архив бүрдүүлэх, баяжуулах.

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээ баримтыг бүрдүүлэх, архивлах, үйлчлэх үйл ажиллагааг зохицуулсан журам боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. - Төв архив болон хөмрөг үүсгэгч, мэдээлэл бүрдүүлэгч 25 байгууллагад архив, мэдээллийн сан бүрдэж, үйл ажиллагаа тогтвортожсон. - Уур амьсгалын мэдээллийн сангийн удирдлагын систем /CliWare-2.1/ болон Цахим баримтын нэгдсэн удирдлагын систем /M_WAMS/-үүдийг салбарын хэмжээнд ашиглаж байна. 	<ul style="list-style-type: none"> - Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллахад архивын болон мэдээллийн технологийн мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байна. - Тоон мэдээллийн бүрдэл, чанарыг шалгаж, баталгаажуулж, хүлээлгэн өгөх үүрэг бүхий хөмрөг үүсгэгч, мэдээлэл бүрдүүлэгч байгууллагуудын өөрсдийн дотоод хяналт сул байна.

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> - Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр цаасан баримтын үйлчилгээний эргэлт багасгаж, түргэн шуурхай үйлчлэх боломжтой. - Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд ус цаг уур, орчны шинжилгээний эх болон боловсруулсан баталгаажсан мэдээллээр “Нэгдсэн мэдээллийн сан” үүсгэнээр үйлчилгээг бүрэн цахимжуулах боломж бүрдэнэ. 	<ul style="list-style-type: none"> - Цаасан болон цахим баримт хадгалалтын горимыг бүрэн хангасан температур, чийгийн зохицуулалт бүхий зориулалтын архивын өрөө байхгүйгээс баримтын хадгалалтын чанар муудах, улмаар устах өндөр эрсдэл дагуулж байна.

Стратегийн зорилт-3: Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга технологийг боловсронгуй болгох

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Цаг агаарт зориудаар нөлөөлех 46 экспедиц, газрын генератор ажиллаж байна. - Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлснээр ган зудын эрсдэл, хуурайшилтэг бууруулах болон ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. - Цаг агаарт зориудаар нөлөөлөх боловсон 	<ul style="list-style-type: none"> - Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, арга зүй, технологийг сайжруулах шаардлагатай. - Орчин үеийн дэвшилтэд техникийн шинэчлэл хийх шаардлагатай. - Тэсэрч дэлбэрэх бодистой харьцах мэргэжлийн боловсон хүчний нөөц дутагдалтай.

хүчнийг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж байна.		
ГАДААД ОРЧИН		
Боломж	Эрсдэл	
<ul style="list-style-type: none"> - Хууль эрх зүйн орчин бүрдсэн. - Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд бусад орны туршлагыг судлах боломжтой болсон. / БНХАУ, Тайланд/ - Цаг агаар зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай зардал шийдвэрлэгдэж байгаа. - Хөрш орнуудад цаг агаарт нөлөөлөх үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаа. 	<ul style="list-style-type: none"> - Олон нийтийн дунд үйл ажиллагааны талаар буруу ойлголт бий болох. - Тэсэрг дэлбэрэх бодистой харьцахдаа технологийн горим, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлаагүйгээс үүдэн хохирол гарах. 	
Стратегийн зорилт 4. Мэдээлэл солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сүлжээ, интернетийн хурдыг нэмэгдүүлэх.		
ДОТООД ОРЧИН		
Давуу тал	Сул тал	
<ul style="list-style-type: none"> - ОХУ-ын Новосибирск бүсийн төв болон Япон улсын цаг уурын байгууллагатай интернетэд суурилсан VPN сувгаар холбогдож мэдээлэл солилцож байна. - Мэдээлэл солилцооны MSS, GTS программ хангамжийг ашиглаж олон улсаас мэдээлэл /BUFR формат/-ийг хүлээн авах болон дамжуулах ажлыг гүйцэтгэж байна. - Хот хоорондын мэдээлэл солилцоонд Мэдээлэл холбоо сүлжээ ХК-ы шилэн кабелийг ашиглан 5mpbs хурдтай интернет, 3mpbs өргөнтэй VPN сувгийг ашиглаж байгаа бол төв байранд 80mpbs хурдтай интернетийг ашиглаж байна. - Хот хоорондын ус цаг уурын ажиглалтын мэдээлэл дамжуулалтад 2018 оноос эхлэн "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем"-ийг шинээр нэвтрүүлэн ашиглаж байна. 	<ul style="list-style-type: none"> - "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем"-ийн хэвийн ажиллагаа, дамжиж буй мэдээллийн ирц, чанарт тавих хяналт сул байна. - Ажиглалтын цэгээс мэдээллийг шууд хүлээн авах боломжийг бий болгох интернетийн найдвартай эх үүсвэр хангалтгүй. Төсвийн зардал хүрэлцэхгүй байна. - Хот хоорондын сувгийн өргөн, интернетийн хурдыг дамжуулж буй мэдээллийн баатгаамжтай харьцуулахад илт бага байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байна. - Орон нутгийн УЦУОШТ-үүдийн холбоо, сүлжээний инженерүүдийн чадавх сул, тогтворт суурьшилтай ажиллах боломжкоор хангахгүй байна. 	
ГАДААД ОРЧИН		
Боломж	Эрсдэл	
<ul style="list-style-type: none"> - Бээжингийн бүсийн төвтэй мэдээлэл солилцох сувгийг Интернетэд суурилсан VPN суваг болгон шинэчилснээр олон улсад мэдээлэл дамжуулах болон хүлээн авах хурд нэмэгдүүлэх. - BUFR форматтай мэдээллийг хүлээн авч боловсруулах, дамжуулахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн програм хангамжийг нэвтрүүлэх. - Хот хоорондын сувгийн өргөн, интернетийн хурдыг нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Хот хоорондын мэдээлэл солилцоонд ашиглаж буй холбоо сүлжээний шилэн кабель тасрахад мэдээлэл дамжуулах нөөц суваг байхгүй байна. - Олон улсаас хүлээн авч буй BUFR форматтай мэдээлэлд кодчлолын өөрчлөлт, шинэчлэлт ороход түүнийг тухай бүр MSS, GTS программ хангамжид өөрчлөлт оруулах, сайжруулах боломжгүй байна. - "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем"-ийн хэвийн аюулгүй ажиллагаа доголдсон тохиолдолд мэдээлэл хүлээн авах нөөц систем байхгүй байна. 	

Стратегийн зорилт-5: Ус, цаг агаар, орчны бодит, түүхэн болон урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг тасралтгүй шуурхай хангах.

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Ус цаг уур, орчны олон жилийн цаасан болон тоон мэдээллийн сан бүрдсэн. - Бодит ажиглалтын 318 өртөө, харуултай хоногт 3-8 удаа ажиглалт хийдэг. Үүнээс 58 % нь автомат хэмжих хэрэгслээр хэмжил гүйцэтгэж байна. - Эдгээр ажиглалтын болон урьдчилан мэдээлэх системийн тасралтгүй 24 цаг ажиллуулах хүний нөөц бүрдсэн. - 2011 онд Суперкомпьютерийн технологийг нэвтрүүлсэн нь урьдчилсан мэдээний чанар, таарцыг ахиулахад ихээхэн түлхэц болсон. - Архив, мэдээллийн санг бүрдүүлснээр хэрэглэгчдэд үйлчилж, байгууллагын төсөвт зохих хэмжээний орлогыг төвлөрүүлж байна. - Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор интернетэд суурилсан мэдээллийн студийг ажиллуулж байна. 	<ul style="list-style-type: none"> - Ажиглалтын станц, харуулудын орон зайн нарийвчлал 150км ээс их. - Ихэнх станц, харуулудын ажиглалтын хоорондох хугацаа 3-8 цаг тул эдгээр үзүүлэлтээс бага орон зайд үүсээд, хөгжөөд сарнидаг үер, аадар бороо, аянга, цахилгаан зэрэг ус, цаг агаарын аюултай, гамшигт үзэгдлийг илрүүлэх боломж бага. - Агаар мандлын дээд давхаргын ажиглалтын сүлжээ хангалтгүй. - Суперкомпьютер, тооцоолох төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан. Хүчин чадал бага байна. - Байгууллагаас гаргаж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажил дутмаг. - Нарийн мэргэжлийн боловсруулалт шаардагдсан мэдээллээр үйлчлэх, хэрэглэгчийн мэдээ баримт хүссэн өргөдлийг шийдвэрлэхэд шат дамжлага ихтэй байгаа нь үйлчилгээний хугацааг удаашруулж байна. - Төрийн албан хаагчийн цалин, нийгмийн хангамжаас шалтгаалан мэргэжлийн боловсон хүчний дутагдалд орж байна.

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> - ДЦУБ-аас чиглэл, зөвлөмж, зааварчилгаа өгдөг, сургалт явуулдаг. - Бусад улс орнуудын туршлагаас хуваалцах боломж байдаг. - Эрх зүйн орчин бүрдсэн. - Шинэ техник, технологийн дэвшил нь хэрэглэгчдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх боломж бүрдсэн. - Шинэ зорилтот хэрэглэгчдийг бий болгох, тэдэнд хүрч ажиллах эрх зүйн орчин бий болгох. - Төр хувийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан үр ашигтай ажиллах боломж олгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж, агаар мандлын үзэгдэл, процессын хэлбэлзэл, хувьсал их болж байна. - Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж, шинэ технологийн нэвтрүүлэлт, технологийн шинчлэлт мэдээллийн технологийн хурдтай зэрэгцэн хийгдэж чадахгүй байна. - Тусгай хэрэгцээний мэдээ мэдээлэл гаргахад техник, технологийн шинчлэл болон нарийвчилсан судалгах хийгдээгүй, хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад хоцрогдож байгаа. - Дэлхийн улс орнуудын хөгжлийн хурд, технологийн дэвшлээс хоцрогдох.

Стратегийн зорилт-6: Ус, цаг агаар, уур амьсгалын гаралтай /ган, зуд/ аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх.

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - ЗГ-ын 2015 оны 286-р тогтоолоор 	<ul style="list-style-type: none"> - Ажиглалтын станц, харуулудын орон зайн нарийвчлал 150км ээс их, ажиглалтын

<p>Сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээнд орох ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн жагсаалтыг баталсан.</p> <ul style="list-style-type: none"> - Ажиглалтын болон урьдчилан мэдээлэх системийн тасралтгүй 24 цаг ажиллуулах хүний нөөц бурдсэн. - 2011 онд Суперкомпьютерын технологийг нэвтрүүлсэн нь урьдчилсан мэдээний чанар, таарцыг ахиулахад ихээхэн түлхэц болсон. - Аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх системийн суурь тавигдсан. 	<p>хоорондох хугацаа 3-8 цаг тул эдгээр үзүүлэлтээс бага орон зайд үүсээд, хөгжөөд сарнидаг үер, аадар бороо, аянга, цахилгаан зэрэг ус, цаг агаарын аюултай, гамшигт үзэгдлийг илрүүлэх боломж бага байна.</p> <ul style="list-style-type: none"> - Цаг уурын доплерын радарын сүлжээ байхгүй. - Ган, зуд зэрэг урт хугацааны аюултай үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх нь онолын хувьд ч, практикийн хувьд ч нэлээд хүндрэлтэй байдаг. - Төрийн албан хаагчийн цалин, нийгмийн хангамжаас шалтгаалан мэргэжлийн боловсон хүчний дутмаг байна.
--	---

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> - ДЦУБ-аас чиглэл, зөвлөмж, зааварчилгаа өгдөг, сургалт явуулдаг. - Бусад улс орнуудын туршлагаас хуваалцах боломж байдаг. - Гамшигаас хамгаалах байгууллагатай хамтран ажиллах. 	<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж, агаар мандлын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал нэмэгдэж, учрах хохирол нэмэгдсээр байна. - Хэрэглэгчдийн хүсэлт, шаардлага тасралтгүй нэмэгдэж байна. - Улс орны хөгжил, хотжилтын нөлөөгөөр хүний ам нас, эд хөрөнгө ус, цаг агаарын аюултай үзэгдэлд өртөх эрсдэл нэмэгдсээр байна. - Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж, шинэ технологийн нэвтрүүлэлт, технологийн шинэчлэлт мэдээллийн технологийн хурдтай зэрэгцэн хийгдэж чадахгүй байна.

Стратегийн зорилт-7: Суперкомпьютерын технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг өргөжүүлэн, хөгжүүлэх.

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Ус, цаг агаар, уур амьсгал, орчны чиглэлийн богино, дунд, урт хугацааны прогноз, агаарын бохирдол, усны урсац, үерийн прогноз, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн тооцооны үр дүнгийн орон зайн нарийвчлал эрс сайжирна. 	<ul style="list-style-type: none"> - Тухайн технологийг нэвтрүүлэхэд өртөг өндөр, техникийн засвар үйлчилгээг байнга хийх шаардлагатай. - Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд хугацаа ихээр шаарддаг.

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> - Монгол орны нийгэм, эдийн засгийн олон салбаруудын энэ чиглэлийн өнөөгийн хэрэгцээ, шаардлага ихсэж байгаа. 	<ul style="list-style-type: none"> - Цахилгааны тогтвортгүй байдал, хөргөлтийн төхөөрөмжийн муу байдлаас болж суперкомпьютер болон төхөөрөмж гэмтэл гарах.

Стратегийн зорилт-8: Уур амьсгалын өөрчлөлтийн Монгол орны экосистемд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх.

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
-----------	---------

- Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги, төлөвлөгөөний шинжлэх ухааны үндэс гарна.	- Олон салбарын судлаачид нөлөөллийн үнэлгээ хийх учир цаг хугацаа их шаардана.
--	---

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээнд суурилан олон улсын санхүүжилт, донороос төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	- Салбарын судлаачдын уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлийн мэдлэг, боловсрол, үнэлгээ хийх арга дутмаг тул үнэлгээг хийхдээ алдаа гарах.

Стратегийн зорилт-9. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийг боловсронгуй болгох, байгууллагын бүтцийг шинэчлэн зохион байгуулах, эрэлт хэрэгцээнд үндэслэн мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.

ДОТООД ОРЧИН

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны төв байгууллагын хувьд улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг нэгдсэн удирдлага зохион байгуулалттай, эрх зүйн орчин бүрдсэн. - Монгол орны 318 сум суурин газарт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлыг 1800 гаруй албан хаагчид гүйцэтгэж байна. - ДЦУБ болон бүсийн төвүүд, бусад орны цаг уурын байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна. 	<ul style="list-style-type: none"> - Салбарын хууль нь орчин үеийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй, зохицуулах боломжгүй байна. - Салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчин дутмаг. - Нийгмийн хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх эдийн засгийн хөшүүрэг хуулиар нарийвчлан зохицуулаагүй. - Цалин, нийгмийн хангамжаас шалтгаалан мэргэжлийн хүний нөөц хомсдолтой. - Төсөв санхүүгийн улмаас ДЦУБ-аас сургалт бусад үйл ажиллагаанд оролцож чадахгүй байна.

ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> - Шинэ техник, технологийн дэвшил нь хэрэглэгчдэд мэдээ, мэдээллийг хүргэх боломж бүрдсэн. - Шинэ зорилтот хэрэглэгчдийг бий болгох, тэдэнд хүрч ажиллах эрх зүйн орчин бий болгох. - Төр хувийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан үр ашигтай ажиллах боломж олгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжтой. - Олон улсын байгууллагуудаас төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээний мэдээ мэдээлэл гаргахад техник, технологийн шинэчлэл хийгдээгүй, хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад хоцрогдож байгаа. - Хууль эрх зүйн орчин тодорхойгүйгээс шалтгаалан санхүү, хөрөнгө, хүний нөөцийн хомсдол бий болох. - Дэлхийн улс орнуудын хөгжлийн хурд, технологийн дэвшлээс хоцрогдох. - Салбарын эдийн засагт үзүүлж байгаа үр өгөөжийг үнэлэн санхүүгийн зөв механизмууд ажиллахгүй, тооцоо судалгааг ашиглахгүй шийдвэр гаргах. - Уур амьсгалын үйлчилгээг системтэй хөгжүүлэгүйгээс уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан манай орны эдийн засагт чухал үүрэгтэй стратегийн салбаруудын дасан зохицох бодлогын үр өгөөж буурах эрсдэлтэй байна.

Зургаа. Стратегийн зорилго:

“Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангана.

**Долоо. Стратегийн зорилтыг хэмжих шалгур үзүүлэлт, сурь болон зорилтот тувшин, стратеги
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Бодлогын баримт бичигт тусгайдсан, болон үндсэн чиг үргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги (арга зам)	Шалгур үзүүлэлт	Сүүрь тувшин (2019)	Зорилтот тувшин (2021-2024)	Санхүүгийн эх үүсвэр, сая.төг	Хэрэгжүүлэх нэж, байгууллагууд
1.	Зорилт-1 Ус цаг байгаль хяналт	1. Цаг уурын өртөө, харуулыг цаг уурын автомат хангах.	Суурилтуулсан станцын тоо	180	280	7.076,0 УТХО, ГЗТ	ЦУОШГ Аймаг, хотын УЦУОШТ-ҮД
2.	Шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник шинэчлэлтэй хийх.	2. Ус, цаг агаарын урьдчилан сэргийлэх дунд, урт хугацааны мэдээ боловсруулах суперкомпьютерийг шинэчлэх.	1. Суурилтуулсан Суперкомпьютерын тоо 2. Чадавхжуулсан инженерийн тоо	1. 1 /Ашиглалтын хугацаа дууссан/ 2. 16 2.	1. 1 2. 16	4.534,7 ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ
3.	Долглерын станцын тоо	Радарын станцын тоо	Радарын станцын тоо	1	4	21.900,0 УТХО	ЦУОШГ, Хэнтий, Өвөрхангай Хөвсгөл аймгийн УЦУОШТ-ҮД
4.	Цаг уурын чийг температурын автомат хэрэгслээр хангах.	Чийг харуулудыг температурын автомат хэрэгслээр хангах.	Чийг автомат хэрэгслээр хангах.	0	181	650,3 УТ-ҮЗ, ГЗТ	ЦУОШГ Аймаг, хотын УЦУОШТ-ҮД
5.	Байгаль орчны шинжилгээний лабораторийн барилгыг төв инженер ажилчдыг чадавхжуулсан эсэх тоноог төхөөрөмжөөр хангах.	Барилгыг орчны шинжилгээний лабораторийн барилгыг шинэчилж, шинэ дэвшилтэй тоноог төхөөрөмжөөр хангах.	Лабораторийн барилгыг оруулж, техникийн ажилчдыг чадавхжуулсан эсэх	-	1	42.561,0 ГЗТ	НХБТГ, ЦУОШГ

6.	Томоохон хот, суурин агаарын 5-аас үзүүлэлтээр Узүүлэлтээр боломжийг бурдулэх.	Агаарын бохирдлыг 5-аас доошгүй чанарыг доошгүй хянах бурдулсэн төвийн тоо	0	9	УТХО, ОНТ, ГЗТ	ЦУОШГ, АНЗДТГ
7.	Ус судалын харуулыг автомат хэмжигчээр тоноглох.	Автомат усны тувшин хэмжигчээр харуулын тоо	58	160.0 УТ-ҮЗ, ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ	
8.	Цаг шинжилгээний сүлжээг өргөжүүлэх.	Шинээр байгуулах цаг уурын өртөөний тоо	18	58	287.3 УТ-ҮЗ,	ЦУОШГ
9.	Гадарын үс судалын 40 харуул шинээр байгуулах.	Шинээр байгуулах үс судалын харуулын тоо	137	5	527.6 УТ-ҮЗ, ГЗТ	ЦУОШГ
10.	Нүүр судалын өртөө байгуулах	Шинээр байгуулах нүүр судалын өртөө тоо	155	40	35.0 УТ-ҮЗ,	ЦУОШГ
11.	Устөрөгч гаргах авах шинэчлэх.	Усыг задалж ус төрөч гарган авах тохижийн тоо	2	2	УТ-ХО, ГЗТ	ЦУОШГ
12.	Болон орон нутгийн орчны хяналт шинжилгээний лабораториудыг итгээмжлэлд хамруулах.	Итгээмжлэлд хамрагдсан лабораторийн тоо	1	4	УТ-ҮЗ	ЦУОШГ, БОХЗТЛ, УЦУОШТ-ҮД
13.	Эталон хэмжих хэрэгсэл, тохируулын төхөөрөмжийг шинэчлэх.	Шинэчилсэн тоног хэмжих хэрэгслийн тоо	-	5	УТХО , ГЗТ	ЦУОШГ, БОХЗТЛ

14.	Зорилт - 2. Ус, Цаг ур, мэдээллийн терийн эрхлэх, болон архив бүрдүүлэх, баяжуулах.	1.Архивын саарчны суурьтай цаасан цахимжууллах.	Цахимжуулсан баримтын зэлзэх хувь	36	40	УТ-УЗ	Цуошг, үцуюшт-үуд
15.	Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга технологийг боловсронтуу болгох.	2.Нэгдсэн цахим мэдээллийн байтуулах.	Нэгдсэн мэдээллийн сан байтуулсан эсэх	-	Тийм	УТ-УЗ	
16.	Зорилт-3 Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга технологийг боловсронтуу болгох.	1.Техникийн шинэчлэл хийх. 2. Цаг зориудаар нөлөөлөх үйл ажиллагаачын чилгэлээр судалгаа хийх, тайллан гаргах.	Техникийн шинэчлэл эсэх Судалгааны тайлангийн тоо	-	Тийм	УТ-УЗ, ГЗТ	Цуошг, үцуюсмх, үцуюшт-үуд
17.	Зорилт-4. Мэдээлэл согилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сужээ, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх.	1.Бээжинглийн бусийн төвтэй мэдээлэл солилцох Интернетэд суурилсан VPN суваг болгон шинэчлэх. 2.Олон улсын хот хорондын ашиглалт, дотоод сулжээ, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх.	Шинэчилсэн эсэх Интернетийн хурд, <i>trbs</i> 2.Хот интернэтийн хурд, <i>trbs</i> 3.Хот хорондын сувгийн зурвасын өргөн, <i>trbs</i>	-	Тийм	УТ-УЗ	Цуошг, үцуюсмх,

Үндсэн чиг урэг -2 : Ус цаг ур., орчны мэдээ, мэдээллийн хангах							
18.	Зорилт-5 Ус, цаг агаар, орчны бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг	1. Цаг агаарын урьдчилсан мэдээний чайршуулах.	Урьдчилсан таарц, хувь 1. 5 хоног, 2. 1 хоног, 3. 12 цаг 4. 6 цаг,	мэдээний 1. 88,6 2. 92,9 3. 93,8 4. 98,9	1. 89,1 2. 93,5 3. 94,5 4. 99,3	УТ-УЗ	ЦУОШГ ҮЦУОШТ-УД
19.	Урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг	2. Сар, урьдчилсан таарцыг сайжруулах.	Урьдчилсан таарц % 1. Сар 2. Улирал	тэлвийн 1. 60% 2. 55%	1. 62% 2. 58%	УТ-УЗ	
20.	Тасралтгүй шүүрхай хангах .	3. Гадаргын урьдчилсан чайршуулах.	1. Бодино хугацааны урьдчилсан таарц, хувь 2. Урт хугацааны урьдчилсан таарц, хувь	хугацааны мэдээний 1.71 2. 70	1.73,5 2. 72,0	УТ-УЗ	ҮЦУОСМХ ҮЦУОШТ-УД
21.		4. Хөдөө аж ахуй Цаг үүрүн мэдээ, мэдээллийн терөл, чайршиг нэмэгдүүлэх.	1. Урьдчилсан мэдээний таарц, хувь 2. Төрлийн тоо	1.65 2. 14	1.75 2.20	УТ-УЗ	
22.		5. Нислэгт зориулсан цаг агаарын мэдээний чайршуулах.	Урьдчилсан таарц, хувь	мэдээний 94,4	94,6	УТ-УЗ	НЦУГ ҮЦУОШТ-УД
23.		6. Агаар, ус, хөрс, цацрагийн хяналт шияжилгээний байгаль орчны төлөв байдлын тайлан гаргах.	Байгаль орчны төлөв байдлын тайланийн тоо	3	5	УТ-УЗ	ЦУОШГ
24.		7. Агаарын бодирдлын эх үүсвэр, хаягдлын бурутгэлийн цахим мэдээллийн сан байгуулах.	Агаарын бодирдлын эх үүсвэр, хаягдлын тоо бурутгэлийн мэдээллийн сангийн тоо	0	1	УТ-УЗ	ЦУОШГ
25.		8. Үйлчилгээг цахимжуулж, өргөжүүлэх.	Цахимаар үйлчлүүлсэн хэрэглэгчийн хувь	зээлэх 10.8%	25%	УТ-УЗ	ЦУОШГ
		9. Байгаль орчны	Шинээр нэмэгдсэн,			УТ-УЗ	ҮЦУОСМХ

		Мэдээллийн өргөжүүлэх, баяжуулах.	санг мэдээллийн тоо	шиначлэгдсэн сангийн тайланийн тоо	дэд сангийн тайланийн тоо	42	46	
26.	10.	Монгол бэлчээрийн байдалын тайлан" гаргах.	орны төлөв үндэсний	Тайланийн тоо	-	1	УТ-ҮЗ	ЦУОШГ, УЦУОСМХ
27.	11.	Мэдээллийн хүртээмжийг сайхруулахын мэдээллийн өргөжүүлэх хөгжүүлэх.	тулд студийг	1.Мэргэжлийн программ хангамжаар хангадсан эсэх 2.Шинэ хүчиний тоо	- боловсон	1.Тийм 2.2	УТ-ҮЗ	ЦУОШГ
28.	28.	Зорилт-6. Ус, цаг агаар, ур амьсгалын гаралтай зуд/ аюултай болон гамшигт Узэгдлээс эртнээс сэргэжүүлэх.	1.Цаг боловон гамшигт урьдчилан сэргийлэх, ончийг нэмэгдүүлэх. 2.Ган, зудын урьдчилан нарийчилалыг сайруулах.	аюултай узвэргээс нарийчилалыг сайруулах.	Урьдчилсан сэргийлэх, сэргэжүүлэх мэдээний онч,% 91.2%	93.2%	УТ-ҮЗ	ЦУОШГ, УЦУОСМХ УЦУОСТ-ҮД
29.	29.			Орон нарийчиллыг түвшинд гаргасан эсэх	-	Тийм	УТ-ҮЗ	ЦУОШГ УЦУОСМХ
Үндсэн чиг Ургийн нэр: Ус цаг уур, орчны эрдэм шинжилгээ, судалгаа хийх								
30.	30.	Зорилт 7. Супер- компьютерийн технологид суурилсан	1.Цаг загварыг таарц, орон зай, нарийчилалыг сайруулах.	агаарын тоон агаарын тоон 2.Хур илтрүүлэлтийн хувь	1.Цаг загварын тоон 2.Хур илтрүүлэлтийн хувь 1.78,2% 2. 2.70%	1.78,7% 2.70%	УТ-ҮЗ	УЦУОСМХ
31.	31.	Цаг агаар, орчны загварчилалын системийг өргөжүүлэх, хөгжүүлэх.	2.Ус, цаг агаар, орчны тухайлсан хосолсон загварчилалын суурийг тавих	Загварын тоо	-		УТ-ҮЗ	УЦУОСМХ
32.	32.		3. Орчил үргсгалын олон загварын ансамбл системийг нэвтрүүлэх.	1.Загварын тоо 2.Ансамбл тоо	1.5 2.110	1.7 2.140	УТ-ҮЗ	УЦУОСМХ

33.		4. Уур амьсгалын динамик загварын анхны систем боловсруулах.	Системтэй болсон эсэх	-	Тийм	УТ-УЗ	УЦУОСМХ
34.		5.Агаарын бодхирдлын тархалтын загварчалын арга технологийг боловсруулж, нэвтрүүлэх.	Шинээр боловсруулж нэвтрүүлсэн технологийн тоо	-	1	УТ-УЗ	ЦУОШГ УЦУОСМХ
35.		6. Зайнцаас тандах системийг нэмэгдүүлэх	Шинээр суурилгуулсан системийн тоо	-	3	ГЗТ	УЦУОСМХ
36.	Зорилт-8.	Уур амьсгалын ёөрчлөлтийн Монгол орны экосистемд	1. Уур амьсгалын ёөрчлөлт, хандлагын заварчалыг нарийвчлах.	Судалгаа, загварчалын ур дун шинэчлэгдсэн эсэх	-	Тийм	УЦУОСМХ
37.		Узүүлэх нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх.	2. Уур амьсгалын ёөрчлөлтийн бүтгээмж, үзүүлэх үнэлгээг гаргах.	Орон зайн нарийвчлыг аймаг, сумын түвшинд хүргэсэн эсэх	-	Тийм	УЦУОСМХ
38.			3.Агро уур амьсгалын нөөц, ёөрчлөлтийг нарийвчлан тодорхойлох.	Судалгааны Тайлангийн тоо	-	1	УТ-УЗ
<i>Барихийн чиг Ургийн нэр: Ус цаг уур, орчны шинжилгээ</i>							
<i>Үндсэн чиг Ургийн нэр: Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах</i>							
39.	Зорилт-9. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай болговсронгуй	1.Хуулийг болговсронгуй болгож, хэрэгжилтийг зохион байгуулах	УИХ-аар шинээр болон шинэчилсэн найруулга, нэмэлт ёөрчлөлт оруулж баттуулхаар бэлтгэсэн хуулийн батлагдсан эсэх	-	Тийм	УТ-УЗ	БОАЖЯ, ЦУОШГ, Харьяа байгууллагууд

боловх, байгууллагын бүтцийг шинэчлэн зохион байгуулах, эрэлт хэрэгцээнд үндэсслэн мэргэжлийн хүний нөөцийг бурдуулэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.	2.Хууль, стратеги төвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.	Агентлагийн байгуулалтын шинэчлэн байгуулсан эсэх	зохион бүтцийг зохион	-	Тийм	БОАЖЯ, ЦУОШГ,
3. Хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг хийж, боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах.	Мэргэжилтэй хүний нөөц бүрдсэн эсэх	-	-	Тийм	-	БОАЖЯ, ЦУОШГ,
4.Холбогдох конвенцийн зорилтыг хэрэгжүүлэх агаар шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, Дэлхийн цаг уурын байгууллага болон олон улсын байгууллагуудтай гадаад, ажиллагааг өргөжүүлэх	Хоёр болон олон талт гэрээний хувь	63.3	70	УТ-ҮЗ, ГЗТ	ЦУОШГ	

Найм. Стратегийн зорилго ба Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал

Цаг уур, орчны шинжилгээний газар нь Монгол Улсын хэмжээнд цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээ хийх, ус, цаг агаар, орчны төлөв байдал, чанарын талаарх мэдээллээр шуурхай үйлчлэх үйл ажиллагааг зохион байгуулж, байгалийн болзошгүй гамшигийн эрсдэлээс эртнээс сээрэмжлүүлэх үүрэгтэй төрийн захиргааны байгууллага болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн дагуу 77 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Тус газар болон харьяа 25 байгууллагад нийт 1893 албан хаагч ажиллаж байна.

Тус газрын Стратегийн зорилго нь “Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөр”-т тулгуурлан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Энэхүү стратегийн зорилго болон Дэлхийн цаг уурын байгууллагын гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд Цаг уур, орчны шинжилгээний газрын бүтцэд зарим өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2016 оны 9 дүгээр сард Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс Урьдчилан мэдээлэх хэлтсийг орон тоо, төсөвтэй нь газарт шилжүүлж, Урьдчилан мэдээлэх хэлтсийг агентлагийн дотоод бүтцийн нэгж болгон шинэчлэн байгуулсан болно. Энэ өөрчлөлтөөр тус хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаатай байнгын уялдаатай ажиллаж байдаг Цаг уурын холбоо, мэдээллийн хэлтсийн ажилтнууд нь Хүрээлэнгийн мэдэлд үлдсэнээс өдөр тутмын шуурхай үйлчилгээний ажлын уялдаа, холбоо алдагдах нөхцөл үүссэн болно.

Өнөөдрийн байдлаар тус агентлагийн харьяа Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Цаг уурын холбоо, мэдээллийн хэлтэс нь Дэлхийн цаг уурын байгууллагын мэдээллийн сүлжээн дэх цаг уурын холбооны Үндэсний төвийн үүргийг гүйцэтгэж байгаа боловч цаг уурын холбоо, сүлжээний өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах, суперкомпьютерт байнга хийгдэх засвар үйлчилгээний болон шинэчлэх зардлыг өөрийн төсвөөс шийдвэрлэх боломжгүй тул тус газраас холбогдох зардлыг 100 хувь санхүүжүүлж байна.

Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Цаг уурын холбоо, мэдээллийн хэлтэс нь 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.


Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн Цахим засаглалыг бий болгох бодлогын хүрээнд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын хэмжээнд мэдээллийн технологийг хөгжүүлэх, шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг цахимжуулах замаар иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг чирэгдэл багатай, шуурхай болгох зорилгоор тус агентлагийн дотоод бүтцэд холбоо, мэдээллийн технологи хариуцсан нэгжийг байгуулан ажиллуулах шаардлагатай байна.

Дээрхи байдал нь Стратегийн зорилго ба Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа хангагдахгүй байгааг харуулж байна.

Иймд тус газрын харьяа Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Цаг уурын холбоо, мэдээллийн хэлтсийн албан хаагчдыг орон тоо, цалингийн зардлын хамт агентлагийн аппаратад шилжүүлэн ажиллуулж, Холбоо, мэдээллийн технологийн хэлтэс болгон шинэчлэн зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр тус агентлаг нь 7 хэлтэс, 25 харьяа байгууллагатайгаар үйл ажиллагаагаа явуулна.

Дээрх бүтцийн өөрчлөлтийг хийхэд шинээр орон тоо, төсвийн зардал нэмэгдэхгүй, батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулах боломжтой юм.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН БҮТЭЦ



Ес. Хавсралт

- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны А/32 дугаар тушаалаар баталсан “Агентлагийн стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”–12 хуудас.
- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/180 дугаар тушаал–1 хуудас

Товчилсон нэрийн тайлал:

ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
НЦУТ	Нислэгийн цаг уурын төв
БОХТЛ	Байгаль орчин, хэмжилзүйн төв лаборатори
УЦУОШТ	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
АНЗДТГ	Аймаг, нийслэлийн засаг даргын тамгийн газар
УТ - ХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УТ - УЗ	Улсын төсвийн урсгал зардал
ОНТ	Орон нутгийн төсөв
ГЗТ	Гадаадын зээл, тусламж